

МААНИЙН УНШЛАГА ТҮҮНИЙ УТГА УЧРЫН ТУХАЙД

Д.НАРАНЦАЦРАЛ

ШУТИС. Хүмүүнлэгийн Ухааны Сургууль

Маань ($\pi \leftrightarrow !$) гэдэг нь Ом Ма Ни Бад Мэ Хум ($\sim \blacklozenge - \pi \leftrightarrow ! - \mu \kappa - \pi \nabla - \} \blacklozenge .$) гэсэн зургаан үсгээс бүтсэн тарни бөгөөд энэ нь Жанрайсиг бурхны зүрхэн тарни юм. Түүний гол утга нь: эх болсон зургаан зүйл хамаг амьтныг энэрэн тэтгэхийн тухай сургааль ажээ.

Мэгзэм гэдэг нь шарын шашныг үндэслэгч Богд Зонховыг язгуурын гурван бурхантай дүйцүүлэн бясалгаж, залбирал үйлддэг нэг төрлийн уншлага юм.

Аливаа сургаал номнол зон олны сэтгэл зүйг эзэмдэн, итгэл үнэмшил болж бишрэл төрүүлэх болтлоо асар их цаг хугацааг туулдагчлан маань, мэгзэмийн уншлага олон зууныг элээн байж Монгол түмний бишрэл, итгэл үнэмшил болж нутагшин малаа маллах, сааль сүүг авах, боловсруулах, аргал түлшээ бэлтгэх, айх эмээх, байгалийн гамшиг тохиолдох, үхэл зовлон тохиолдох, алжаал тайлж амарч суух зэрэг ажил, амьдралын бүхий л талбарт явж, суух мөчдөө аялгуулан унших сүсэглэлийн нэгэн төрөл болсоор эдүүгээ хүрч ирсэн уламжлалт соёл юм.

Маань, мэгзэм нь Монгол нутгийн буддын шашинт сүм хийдийн аялгуут уншлагад шинэчлэл хэлбэрээр орж ирж, сүсэгтнүүд олноороо хоолой нийлүүлэн аялгуулж, уран сайхны мэдрэмжээр сүсэглэх монголын гэсэн өвөрмөц өнгө аястай болж нутагшихдаа ардын дуу, бөөгийн дуудлага, малчдын мал тойглох, ингэ хөөслөх болон тууль хайлах аялгуунаас ямар нэг хэмжээгээр зээлдэн авч ардын уламжлалт соёлын үнэт өв сан болсон хэмээн үзэж болох мэт санагдана.

Маанийн үүсэл хөгжлийн тухайд

Маань, мэгзэм нь Буддын шашны хурал номын утга агуулгатай шууд холбоотойгоор үүссэн тул түүнийг Буддын шашинтай холбон авч үздэг нь санаандгүй хэрэг биш юм.

"Буддын шашин эртний Энэтхэгт үүсээд улмаар Ази дорно дахины олон улс орноор түгэн дэлгэрч, тэдгээр улс үндэстний нийгэм соёлын амьдралын бараг бүхий л салбарыг хамран зонхилж, нарийвчлагдан боловсорсоор ирсэн хүн төрөлхтөний оюун соёлын нэгэн томоохон хэсэг нь

даруй мөн" / 4.4 / ажээ. Монгол оронд буддын шашны дэлгэрсэн зам мөрийг дараах хэдэн үед хуваан авч үзэж болно. Үүнд:

- МЭ I-III зуунд Хүннү удмын ордныхны хүрээнд анх дэлгэрч 3 метр өндөр Сютувангийн алтан бурханыг сүсэглэн тахиж байв.

- Чингис хаан өөрөө тэнгэр шүтлэгтэн байсан боловч аливаа шашныг алагчилан гадуурхдаггүй байснаас Их Монгол улсын үед Буддын шашны нүүдлийн сүм хийдүүд олон болсон түүхтэй учир Буддын шашны дэлгэрэлтийн нэг үе байсан гэж үзэж болох юм. Тухайлбал: 1268 онд Төвдийн Пагва лам Лодойжанцаныг нийслэлдээ урин залж, багш шавийн барилдлага тогтоож, хөрш гурван хааны номын цол хүртээсэн, мөн шашны



хууль цаазыг гаргаж, буддын шашныг Монголын их Юан гүрний үед Хубилай хаан төрийн шашин болгож төр, шашныг хослон барих хоёр ёсыг сахиж байв.

- XVI - XVII зууны заагийн улс төрийн бутралын үед Алтан хаан басуун, зүүн болж хуваагдан сэргөлдөж агсан Монгол зоны эв нэгдлийг сэргээхэд буддын шашны номнолыг ашиглахыг оролдож, Төвдийн Содномжамц хуврагад Далай лам гэдэг цолыг анх өргөмжилснөөр их хөлгөний ёсыг баримталдаг гэлүгва буяны ёс буюу (шар

малгайтны) урсгал Монголд түлхүү орж ирсэн энэ үест буддын шашин хүчтэй дэлгэрсэн гэж үздэг байна.

Харин Халхын ноён Автай Монголд шарын шашин дэлгэрүүлэхээр Содномжамцтай тохиролцож байснаас гадна 1580-аад оны дундуур Халх дахь шарын шашны анхны суурин хийдийг Шар азарга хэмээх Шанхат уулын ард Тахай нэртэй газар байгуулсан байна. Энэ бүгдээс үзэхэд буддын шашин Монголчуудын олонхийн итгэл үнэмшил, шүтлэг болох нь алхам алхмаар гүнзгийрч, төр нь ёс суртахуун, соёл, зан заншил, ахуй амьдралын хүрээнд нөлөөтэй субъект болсоор байсан үед **маань**, **мэгзэм** ч нэгэн адил Монголчуудын олонхийн амны уншлага болж дэлгэрсээр байсан нь мэдээж билээ. Харин 1639 онд Халх Монголчууд шарын шашныг нийтээр зөвшөөрч түүний тэргүүнийг дотроосоо өргөмжилж 1640 онд Монгол Ойрадын Их цааз хуулиар шарын шашныг төрийн шашин болгон хуульчлан баталгаажуулсан бөгөөд тэр нь Манжийн эрхшээлийн үед "Хээрийн салхи шиг догшин Монголчуудыг хоттой хонь шиг номхон болгэх" бодлогод нийцэж, улам

хүчтэй дэлгэрч **маань, мэгзэм** нь Монгол хүн бүрийн аврал энэрэлийн итгэл үнэмшил болжээ.

Буддын шашны сүсэгтэн олны итгэл, сүсэг бишрэлд нийцүүлэн бүтээсэн маанийн нэрийн талаар товч өгүүлье.

Маань гэдэг нь: аливаа хүн, амьтныг зовлонгоос ангижруулагч тарни юм. "Тарни бол заавал санскрит хэлээр уншдаг, аливаа тусыг бүтээхэд зориулсан номын нэр." / 3.47/

Маанийг шашин номын уншлагаас эш татан эх болсон зургаан зүйл хамаг амьтны тусын тулд Ом ма ни бад мэ хум хэмээн уншдаг болжээ.

Төвд үсгээр (~♦-π-↔!-μκ-π∇-}♦.) гэдэг нь орчин үеийн Монгол хэлээр бол "Бадамлянхуа цэцэг доторхи эрдэнийн чулуу" гэсэн үг ажээ. Үг зүйн утгыг авч үзвэл Маань гэдэг нь (π-↔!-.) ма ни гэдэг үг сунжирч хэлэгдсээр маань гэгдэх болжээ. Ма-ни гэдэг нь санскрит үг бөгөөд орчуулбал Норов /эрдэнэ/, монгол руу хөрвүүлбэл чандмань эрдэнэ гэсэн утгатай үг ажээ.

Төвдөөр: norbu буюу :. (λ#ψ-οΞ-ψ!λ-μ#-φ'..)

Монголоор: M.: Candmani /эрдэнэ/

Санскритээр: S.: mani /mani-rat-na/ (π-↔!-.)

Ом ма ни бад мэ хум хэмээх маанийн Ом (Om), Хум (hun) буюу маанийн эхлэл төгсгөлийг авч үзэхэд "Ом-ын бэлгэдэл нь лагшин¹, зарлиг², таалал³ бөгөөд энэ гурвын шид бүтээл хайрлан соёрхохыг хум-аар бэлгэддэг байна." /4.61-62/.

Бад мэ гэдэг нь S.: (μκ-π'.) (padme) буюу бадамлянхуа цэцэг гэж орчуулагдах ажээ. Бадма нь Монгол, Төвд хэлэнд эрт орсон Самгарьд үг болно.

Тарни нь өөрийн дэг жаягтай, сэтгэлийн хүчийг өөр газар руу эс явуулан, нэгэн чигт төвлөрүүлэн хуримтлуулж байж зорилтдоо хүрдэгт түүний гол агуулга оршдог. Жанрайсиг бурхны зүрхэн тарни хэмээн алдаршсан маанийн гол агуулгыг хэдэн арван янзаар тайлбарласан уламжлалт тайлбар байдаг боловч энэ удаад, нэлээд алдартай найман тайлбарыг дурдъя.

Нэг. Маанийн зургаан үсгийн утга нь ямар их аугаа хийгээд өргөн утга агуулгатай болохыг санаж Ом ма ни бад мэ хум гэсэн зүрхэн тарнийг унших нь хүн бүрт тэр дундаа ариун бус бие, хэл, сэтгэлтэнд энэрэлийн асар их ач тустай юм. Эхний Ом үсэг нь А,О,М гэсэн гурван авианаас бүтнэ. Эдгээр нь

Бурхан багшийн ариун лагшин, зарлиг таалал хийгээд мөрөөр замнагчийн ариун бус бие, хэл, сэтгэлийг бэлэгдэнэ.

Ариун бусын бие, хэл, сэтгэлийг ариун лагшин, зарлиг, таалалд хувиргаж болох уу, эсвэл эдгээр нь огт тусдаа зүйлс үү? Бүх бурхад бидний адил төрөлхтөн байгаад зам мөрөөр замнан гэгээрэлд хүрсэн ба Бурханы шашинд анхнаасаа бүх л эрдмүүдийг эзэмшсэн хийгээд огт гэмт үйл үйлдээгүй нэгэн гэж байхгүй хэмээн үздэг. Бага багаар ариун бусыг гээн ариунд хувирснаар ариун бие, хэл, сэтгэлийн дэвшил ирдэг.

Үүнийг хэрхэн үйлдэх вэ? Дараагийн дөрвөн үсгээр зам мөрийг бэлэгдэнэ. Чандмань эрдэнэ гэсэн утга бүхий Ма ни гэдэг үг нь бусдын тусын тулд гэгээрэлд хүрэхийн арга болох энэрэн нигүүлсэхүй болон асрал хайрыг бэлэгдэнэ. Чандмань эрдэнэ ядуурал хэосролыг арилгадагийн адил бусдын төлөө гэсэн гэгээрсэн сэтгэл нь ядуу хоосон, бэрхшээл зовлон, амьдралын хүрдэн болоод дияанчийн амгалангаас ангижруулдаг. Мөн чандмань эрдэнэ нь хамаг амьтны хүслийг биелүүлдэг шиг бусдын тусын тулд гэгээрэлд хүрье гэсэн сэтгэлээрээ хамаг амьтны хүслийг хангагч эрдэнэ юм.

"Бад мэ гэсэн дараагийн хоёр үсэг нь лянхуа буюу ариун гарвалт гэсэн агуулгатай бөгөөд билиг оюуныг бэлэгдэнэ. Шавар балчигаас ургах лянхуа цэцэг намгийн шаврын цөвөөр гундан бохирддоггүйн адил билиг оюуныг тунгалаг толь мэт болгож чадваас бүрхэг байх үед үүсдэг, үүсэх боломж бүхий л зөрчил аяндаа үгүйсгэгдэнэ. Мөнх бусын мөнх чанарыг зөв, төгс танин мэдсэн билиг ухаан, бодгалийн оршихуйн язгуур хоосон чанар буюу бидний танин мэдэхүйн тогтсон үнэлэмжээс үл хамаарах бодитой оршихуйн хоосон чанарыг зөв танин мэдсэн билиг оюун, танин мэдэхүйн оногдохуун ба танин мэдэгч хоёрын хоорондын ялгаа буюу хосмол орших чанарыг зөв таньсан билиг оюун, юмс үзэгдэл бидний эгэлийн танин мэдэхүйн шинжээс үл хамааран мөн чанараасаа хоосонг зөв таньсан билиг оюун гэх мэт бэлгэ билэгийн түвшин ба түвшин ба хэлбэрийн онц ялгаа байдаг ч тэдгээрээс чухам юмсын язгуур чанар хоосон болохыг зөв таньсан билиг оюун нь онц эрхийн гол нь билээ.

Сүүлчийн үсэг болох хум нь хослон барилдахыг бэлэгдэх ба арга билгийн хоорондын салшгүй нэгдлээр гэгээн ариунд хүрэх юм. Судрын ёсонд аргаар тэтгэгдэх билиг, билгээр тэтгэгдэх арга нь арга билгийн салшгүй нэгдлийг харуулдаг. Тарнийн ёсонд арга билгийн хослон барилдсан харилцааг хамтад нь багтаасан нэгэн ухамсарын тухай яригдаж байна.

Язгуурын таван бурхдын эрдэм увидасын үр үсгийн хум нь Акшоба бурханы увидасын үр үсэг бөгөөд юугаар ч өөрчилж болохгүй хөдөлшгүй, тогтвортой гэсэн үг юм.

Арга, билгийн хослон барилдсан харилцаа болох зам мөрөөр замнаснаар өөрийн ариун бус бие, хэл, сэтгэлийг Бурханы ариун, өндөр дээд лагшин, зарлиг, таалал болгон хувиргах боломжтойг Ом ма ни бад мэ хум зургаан үсэг бэлэгдэнэ. Бурханы хутгийг өөрөөсөө ангид хайгаад хэрэггүй, Бурханы хутагт хүрэх бүх л боломж нь "эерт тань бий" гэжээ. / 3.34 /

Хоёр. Маань нь аливаа юмсыг сайн сайханд хөтлөх гэсэн санаа агуулагддаг учраас хүний хийсэн мянга түмэн нүгэл, өвчин зовлонгоос аварна хэмээн сүсэглэж, эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын тулд бодь сэтгэлээр унших ёстой ажээ.

"Эх болсон зургаан зүйл, хамаг амьтан гэдэгт: бурхны сургаалийн дөрвөн төрөлхтөн, зургаан төрөл амьтан багтдаг. Дөрвөн төрөлхтөн хэмээх нь хүн, амьтан, араатан жигүүртэн, сахиулсан, харин зургаан төрөл амьтанд:

- | | |
|---------------------------|-----------------------------------|
| - Тамын амьтан | - Бирдийн амьтан |
| - Адгуус амьтан /мөлхөгч/ | - Хүний төрөлхтөн |
| - Тэнгэрийн амьтан | - Асурийн /диваажин/ амьтад орно. |

Үүнээс хүн, тэнгэр, диваажингийн амьтдыг нь сайн заяаны, тамын, бирдийн, мөлхөгч амьтдыг муу заяаны амьтад" гэж үздэг ажээ. / 5.93/.

Ийнхүү маанийг зовсон амьтан жаргаж, сайн төрлийг олон нирваан болоосой хэмээн сэтгэл оюундаа бясалган уншсанаар энэрэн нигүүлсэхүйн сэтгэлийг төрүүлдэг ажээ.

Гурав. Маанийн зургаан үсэг нь бүх бурхдын бүгдийн нигүүлсэнгүй сэтгэлийг хурааж, сансрын хязгаарыг хүртэл энэлэн шаналсан амьтанд нэгэн даруйдын хийгээд өнө үүрдийн тус амгаан бүхнийг хайрлагч үлэмж дээд нигүүлсэнгүй сэтгэлийн эх сан гэж үздэг байна.

Санскритээр Аръяалогишвара	S.: Ariya Lokeshvara
Төвдөөр Жанрайсиг	T.: spynrasgzigs (

$\leq \lambda - \psi | - \chi \varpi' \chi |.$)

Монголоор Хутагт нүд бээр үзэгч M.: Qutugtu nidu-ber ujegci гэдэг бурхны зүрхэн тарнийн утгыг шингээсэн ажээ. Хутагт дээд Жанрайсиг бурхны зүрх болсон маанийн ач тус эрдмийг судар тарнийн тоолошгүй олон номонд бишрэн өгүүлсэн байдаг юм. Хутагт Жанрайсиг бурхны зүрхэн их тарни зургаан үсэг нь арван зүгийн гурван цагийн бурхан⁴ бүгдийн ч бас

зүрхэн тарни мөн болно. Энэхүү тарни нь машид олохуйяа бэрх, мэдэхүйеэ бэрх, бүтээхүйеэ бэрх болов чиг олж, мэдэж, бүтээж чадах юм бол ач тус эрдэм нь гайхамшигт увидаст чанарт хүрнэ хэмээн судар тарнийн олон номонд дурьджээ.

Дөрөв. Богд Зонхов "Бодь мөрийн зэрэг" зохиолдоо хүнийг гурван төрөлхтөн болгож ангилаад, тус бүрд нь сургаалаа номлосон. Түүний баримтлах зарчим нь "аливаа юманд дэс дараа байх ёстой. Багаас их рүү шилжих замаар явагдах ёстой" гэдэг санаанд төвлөрдөг.

- 1) Бага төрөлхтөн
- 2) Дунд төрөлхтөн
- 3) Их төрөлхтөн



Үүний бага төрөлхтөний сургуулд буян нүглийн тухай өгүүлдэг. Арван цагаан буян гэдэг нь: арван хар нүглийг үйлдэхгүй байхыг хэлнэ. Арван хар нүгэл гэдэг нь: бие, хэл, сэтгэлээр үйлдэх нүглүүд болон дэв бузрыг үүсгэгч муу заяа юм. Бие, хэл, сэтгэл гурван нүгэл гэж байх бөгөөд биеэр үйлдэх гурван нүгэлд:

1. Амьтны амь таслах
2. Өгөөгүйг авах буюу хулгай хийх
3. Буруу хурьцал

Эдгээрийн дотроос урьдах нүгэл гэгдэх амьтны амь таслахыг хүнд нүгэлд тооцдог юм.

Түүнчлэн хэлээр үйлдэх дөрвөн нүгэлд:

4. Худал ярих (урвуулан өгүүлэх)
5. Хов үг хөөцөлдөх (хагацуулах)
6. Ширүүн үг хэлэх буюу хэрэлдэх
7. Чалчаа яриа ярих буюу ямар ч утгагүй дэмий, хоосон үг ярих зэрэг ордог байна. Энэ дөрвөн нүглийн урьдах нүгэл буюу худал ярихыг нь илүү хүнд нүгэл гэж үздэг байна.

Түүний зэрэгцээ сэтгэлээр үйлдэх гурван нүгэлд:

8. Хомхой сэтгэл буюу шунал
9. Хорто сэтгэл буюу атаархал
10. Буруу үзэл (Үгүйсгэх)

Сэтгэлээр үйлдэх гурван нүглийн хойдох нүгэл гэгдэх буруу үзэл нь хүнд нүгэлд тооцогдох ажээ.

Ийнхүү дээрх арван хар нүглийг арилгая гэвэл маанийн зургаан үсгийг сүсэглэн унших хэрэгтэй.

Тав. Ом гэдгийн утга нь бурхны лагшин, зарлиг, таалал гурав бөгөөд тэр гурвын шид бүтээлийг хайрлагтун хэмээхийг хум гэсэн үсгээр дурдан сануулж байдаг. Ом гэдэг нь бурхны дээд эрдэм буюу бясалгал⁵ юм. Бидний хэлдэг **"Умаа хум"** гэдэг үгийн утга учир нь энэ бүхнийг хураан товчилсон үг юм. Үүнээс гадна ум хумгүй алга болох юм гэж Монголчуудын ярианы хэлэнд хүртэл хэрэглэгдсэн байдаг.

Зургаа. Судрын ёсонд зургаан зүйлийн хамаг амьтан ямагт зовлонгийн шинжийг агуулдаг хэмээдэг. Тухайлбал:

Тамын амьтан халуун хүйтнээр энэлэхийн зовлонтой

Бирдийн амьтан өлсөх ундаасахын зовлонтой

Адгуус амьтан алагдах, асгихдын зовлонтой

Хүмүүний амьтан төрөх, өвдөх, өтлөх, үхэхийн зовлонтой

Асури нар тэмцэлдэх хатгалдахын зовлонтой

Тэнгэр нар урт наслахын зовлонтой.

Энэ зургаан зүйл тус тусын зовлонг маанийн зургаан үсгийн гэрлийн адистэд¹⁹-т эрдмээр арилгана хэмээн үздэг. Тиймийн тул:

"Ом" үсгээс сацарсан рашааны гэрлийн эрдмээр тамын зовлонг

"Ма" үсгээс сацарсан рашааны гэрлийн эрдмээр бирдийн зовлонг

"Ни" үсгээс сацарсан рашааны гэрлийн эрдмээр адгуусны зовлонг

"Бад" үсгээс сацарсан рашааны гэрлийн эрдмээр хүний зовлонг

"Мэ" үсгээс сацарсан рашааны гэрлийн эрдмээр асурийн зовлонг

"Хум" үсгээс сацарсан рашааны гэрлийн эрдмээр тэнгэрийн зовлонг арилгана хэмээн үздэг" /3.83-84/.

Долоо. Ом гэдэг нь таван бэлгэ билгүүн³ төгсөхийг бэлгэдсэн буюу цогц таван бурхныг⁷ бэлгэддэг.

Ма гэдэг нь энэрэн нигүүлсэхүй бүхэнд төгсөхийг бэлгэдсэн.

Ни гэдэг нь зургаан зүйл хамаг амьтныг зовлонгоос удирдан жолоодохыг бэлгэдсэн.

Бад гэдэг нь зовлон бүгдийг амирлуулахыг бэлгэдсэн.

Мэ гэдэг нь хилэнцийн дэв бузар бүгдийг шатаахыг бэлгэдсэн.

Хум гэдэг нь эрдэм бүгдийг хураахыг бэлгэдсэн байдаг байна.

Нийт энэ зургаан үсгийн (нууц увидас) адистэдийн эрдмээр үл зохилдох, бууран доройтох бүгдийг амирлуулан арилгаад эх мэт болсон

амьтан бүгдийг зовлонгоос гэтэлгэхийн зам мөр дор оруулан удирдахыг номложээ.

Найм. “**Ом** – Тэнгэрийн үсэг нь: Бэлгэ тэмдэг төгссөн тул дотрын ад гурван нисваанисыг⁸ магад амирлуулах.

Ма – Огторгуйн үсэг нь: Тачаангуй ба лусын хамаг адуудыг дарах.

Ни – Усны үсэг нь: Уур ба эр адуудыг дарах.

Бад – Газар шорооны үсэг нь: Мунхаг ба эм адуудыг дарах.

Мэ – Галын үсэг нь: Дотрын адууд болон хамаг муу авъяасуудыг дарах.

Хум – Хийн үсэг нь: Тотгорын наян дөрвөн мянган тоотон адуудыг даран үйлдмүй” [8.83-84] хэмээн номлосон байдаг.

Маанийн зургаан үсэг нь таван махбсдыг чөлөөлж, гай тотгорын адуудыг дарах чадалтай ажээ.

Ес. Ертөнцийн бүх юмсыг бодитой оршиж байна гэж боддог боловч хоосон чанарын илт онохуйн ухаанд: “хуран бүтсэн юм гэж хуран бүтээгүй юмыг хэлдэг юм” гэж тайлсан. Орчлон ертөнц болон ертөнцийн юмс бүхэн өчүүхэн тоосонцроос хуран бүтдэг бөгөөд хуран бүтсэн бүхэн эргээд бага багаар салсаар хуран бүтээгүй юм болдог тул мөнх биш болно. Жишээ нь: сандал нь тоо тоймшгүй тоосонцроос бүтэж бий болсон хэдий ч элэгдэж хорогдсоор үгүй болж эвдэрдэг. Иймд юм бүхэн мөнх биш тул сэтгэл оюундаа нигүүлсэхүй сэтгэлийг төрүүлж эх болсон зургаан зүйл, хамаг амьтны тусын тулд энэ маанийг унших ёстой ажээ. Эрдэм бүгдийг дэлгэрүүлбэл өөрийн сэтгэл дотроо ч бурхан гэгчийг буй болгож нирваанд хүрч болно гэж үздэг. Бурхан гэдгийг:

Санскритээр S.: buddha

Төвдөөр T.: sangsrgys (|δ|–N|.)

Монголоор M.: (burqan) хэмээх бөгөөд

|δ|.- сан гэдэг нь арилах, N|- жай гэдэг нь дэлгэрэх гэсэн утгатай.

Утгачилбал гэм бүгдээ арилгаж, эрдэм бүхнээ дэлгэрүүлнэ гэсэн үг юм. Товчоор авч үзвэл гэмээ арилгаж, эрдмээ дэлгэрүүлж чадвал бурхны сургаал бүтэж буй нь тэр юм.

Арав. Маанийн зургаан үсгийн тус бүрийн эрдмийг судрын ёсонд өгүүлэхдээ:

Ом гэдэг нь таван бэлгэ билиг (ξA–{A|–P.) төгсөхийг үзүүлэх бөгөөд Таван бэлгэ билиг гэдэг нь:

1. Толийн бэлгэ билиг ($\pi\forall-\zeta\#\delta-Y-\omega!-\xi\forall-\{\forall|\cdot\}$) – толь мэт тунгалаг ариун

2. Тэгш чанарын бэлгэ билиг ($\pi\eta\pi-\mu-\eta!k-\angle!-\xi\forall-\{\forall|\cdot\}$)

3. Тусгайд онох буюу тус тус дор (өөр өөр) онохуйн бэлгэ билиг ($|\#-|\#\psi-\Phi\#\chi|-\mu\omega!-\xi\forall-\{\forall|\cdot\}$)

4. Үйл бүтээлийн буюу үйлсийг бүтээхүйн бэлгэ билиг ($\Pi-o-o\sqcup o-\mu\omega!-\xi\forall-\{\forall|\cdot\}$)

5. Номын агаарын буюу чанарын бэлгэ билиг ($\phi\#|-\angle!-k\Pi\delta|-\angle!-\xi\forall-\{\forall|\cdot\}$)
лүгээ энэ тав болох бөгөөд:

1. Мижиддорж бурхныг Толийн бэлгэ билгүүнд,
2. Ренчинжумдан бурхныг Тэгш чанарын бэлгэ билгүүнд,
3. Нанваантаяа бурхныг Тусад дор буюу мөн хэвээр онохын бэлгэ билгүүнд,
4. Дон ёд Дондүв бурхныг Үйлийг бүтээх бэлгэ билгүүнд,
5. Намбар Нанзад бурхныг Номын агаарын бэлгэ билгүүнд шүтсэн гэх бөгөөд лагшин бие нь энэхүү таван бэлгэ билгүүн дор мөргөж магтсан байдаг." ажээ. [3.3 а тал].

Энэхүү Мижиддорж, Ренчинжумдан, Нанваантаяа, Дон ёд Дондүв, Намбар Нанзад бурхдыг язгуурын таван бурхан гэдэг.

Иймээс **Ом** гэдэг үгийг тайлбарлахад эх болсон зургаан зүйлийн амьтан бүгд мунхгийн гэмээр харанхуйлагдсан байдаг учир мунхгийн харанхуйг арилгадаг юм нь энэ таван зүйлийн төгс чанарт бэлгэ билиг болно. Энэхүү таван бэлгэ билгийн гэгээгээр харанхуйг арилгана. Нэгэнт мунхгийн харанхуйг арилгах таван бэлгэ билиг төгсвөл энэрэн нигүүлсэхүй сэтгэл бүхэнд түгээмэл болно хэмээн номлосон байдаг.

Ма үсгээр ийм бүхэнд түгээмэл нигүүлсэнгүйн сэтгэл төгсөхийг үзүүлжээ. Нэгэнт энэрэн нигүүлсэхүй бүхнийг хайрлах сэтгэлтэй болж чадвал зургаан зүйлийн амьтныг удирдан хөтөлж чадна гэж үздэг.

Тиймээс **Ни** үсгээр зургаан зүйлийн амьтныг удирдан хөтлөх санааг тусгасан байдаг. Зургаан зүйлийн амьтныг удирдан хөтөлж чадваас тэдний зовлон бүгд арилна гэж үздэг.

Тиймээс **Бад** гэдэг үсгээр зовлон бүгдийг арилгах санааг илэрхийлжээ. Зовлон бүгдийг арилгахад хилэнц, түйтгэрийг шатаан үйлдэх нь чухал бөгөөд

Тиймээс **Мэ** үсгээр тэр бүх хилэнц түйтгэрийг шатаан үйлдэх утгыг илэрхийлжээ.

Ингэж таван бэлгэ билгүүн төгсөж нигүүлсэхүйн сэтгэл бүхэн дор түгээмэл болж, зургаан зүйл амьтныг сайнд удирдаж, зовлон бүгд амирлаж (алга болж) хилэнц түйтгэр бүгдийг шатааснаар тэрхүү зургаан зүйл амьтанд эрдэм бүгд хурж ирэх болно гэж үздэг.

Тиймээс эцсийн **Хум** үсгээр эрдэм бүгд хурж ирэхийн утгыг илэрхийлжээ.

Маань нь нийгмийн аль ч үед хүн төрөлхтөн зовлон зүдгүүр, гуниг зэргээсээ салах гэсэн оюун ухааны бодрол, бясалгал юм.

Арван нэг. Маанийн зургаан үсгээр төлөөлүүлдэг эх болсон зургаан зүйлийн амьтдыг "Сансрын хүрдэн"-ий зарим ухагдахуун болгож тайлбарладаг.

"Сансрын хүрдний төв дугуйд хүний ухамсарт үйл хийгээд түүний аливаа нүгэл хилэнцийн эх сурвалж болсон гурван гэмийг гахай, могой, тахиа гурваар илэрхийлсэн байна. Гурван хор ($\chi_k \square \chi - \chi | \exists \pi$) – д мунхаг ухааныг гахайгаар, уур хилэнг могойгоор, тачъяангуй сэтгэлийг тахиагаар дүрсэлсэн нь бурхан шашны ёс суртахууны үүднээс энэ гурван хор нь нүгэл бүхний шалтгаан нь болдгоос үүдэлтэй.

Монголчууд ертөнцийн гурван муу заяаны амьтанд:

Уур ихтэн могой


Идэш ихтэн гахай

Тачъяал ихтэн тахиа гэж хэлдэг нь сансрын хүрдний ухагдахуунаас үүдэлтэй юм байна.

Түүний дараах том хүрээнд гурван сайн, гурван муу заяаны зургаан зүйл амьтны явдал-мөрийг харуулсан дүрслэл байдаг. Үүнд:

1. Тамын орон ($\phi \# | - N \zeta$). Нүгэлтний хийсэн үйлийг сүнсээр нь эдлүүлж барах тусгай орныг хэлэх бөгөөд зургийн дээд хэсэгт тамын эзэн Эрлэг Номун хааны ордон байна.
2. Бирдийн орон ($\xi ! - \partial \chi |$). Сансрын хүрдний биаруун хэсэгт байна. Түүнийг нигүүлсэхүйн орон ч гэж бас нэрлэнэ. Бирдийн зовлон нь байнгын өлсөж явдагт оршино.
3. Адгуусны орон ($\omega k \square k - \omega \int \# - \chi \lambda |$). Сансрын хүрдний амьтны орныг хэлнэ.
4. Хүний орон ($\pi ! \omega ! - \chi \lambda |$). Сансрын хүрд дэх хүний орныг хэлнэ.

5. Асурийн орон. ($\Psi-\pi-\xi!\lambda-\textcircled{R}!-\chi|.$). Сансрын хүрдэнд Асурийн орон хуяг, дуулгатай хүмүүсээр дүрслэгдэнэ. Тэд тэнгэрийн орныхонтой байнга тэрслэх бөгөөд түүний дараагийн орныг
6. Тэнгэрийн орон ($\Psi\omega!-\chi|.$). Сансрын хүрд дэх тэнгэрийн орон. Хурмастын эзний ордоор дүрсэлсэн байдаг.



Зураг №2 Сансрын хүрдэн

Сансрын хүрдэн дээр Эрлэг хаан ($\phi\#|-\text{N}\zeta..$) буюу тамын эзэнд шигшигдэн ирсэн нүгэлтний хэргийг шүүж байгаагаар дүрсэлжээ. Эрлэг хаан хүн бүрийн буян нүглийг харагч толио барьж сууна. Гадар хүрээнд арван хоёр шүтэн барилдлагын агуулгыг ертөнцийн үйл явдалд зураг дүрээр үлгэрлэж үзүүлсэн байдаг. Тухайлбал:

1. Арван хоёр шүтэн барилдлагын анхных болох "Мунхаг"-ийг сансрын хүрдэнд өтөл сохор эмгэнээр үлгэрлэж байна. Хуран үйлдэхийн шалтгаан нь мунхаг учраас анхны шүтэн барилдлага болж байна. ($\zeta\#\delta-\chi.$)
2. Нэр ба өнгө. Зургаан мэдрэхүйн шалтгаан нь хуран үйлдэх учраас үүнийг сансрын хүрдэнд ваарчингаар дүрсэлжээ. ($\Lambda\pi-\beta\lambda.$)
3. Бич ($\{ \forall \omega \Xi.$)
4. Сал онгоц ($\int \square-\Lambda!\delta-.$)

5. Төрөн түгэхүй. Хүрэлцэхүй нь сонсох, үнэрлэх, амтлах, хүртэх, харах дотоод зургаан мэдрэхүйг хэлнэ. Үүнийг сансрын хүрдэнд хоосон байшингаар дүрсэлжээ. ($\beta\delta-\otimes\#\delta-$)
6. Хүрэлцэхүй. Мэдрэхүйн шалтгаан нь хүрэлцэхүй учраас үүнийг сансрын хүрдэнд эр, эм хүнээр дүрсэлжээ. ($\pi!-\chi\eta!|- \omega\#-\Pi\forall\kappa-o.$) – хурьцагч хоёр хүн.
7. Мэдрэхүй. Хүсэх нь мэдрэхүйн шалтгаан учраас үүнийг сансрын хүрдэнд нүд рүүгээ сум харвуулсан буюу нүдэнд нь сум туссан хүнээр дүрсэлжээ. ($\pi!\chi-\zeta-\pi\kappa\omega-v\#\chi-\mu.$)
8. Хурьцах. Авах нь хурьцахын шалтгаан учраас үүнийг сансрын хүрдэнд аягатай дарс барьсан, архи уугч хүнээр дүрсэлжээ.
9. Авах. Үүнийг модноос үр жимс хурааж байгаа хүнээр дүрсэлжээ. ($\{!\delta-i\#\chi-\zeta\forall\lambda-\mu.$)
10. Сансар буюу ертөнцийн хуурамч юманд тэмүүлэх төрөлхийн сэтгэлийг жирэмсэн эмээр харуулжээ. ($\lfloor\Box\pi-\pi.$)
11. Төрөх. Сансрын хүрднүүдийг нярайлж байгаа (хоёр хөлийн дунд нь хүүхэд харагдана) бөс эд нөмөрсөн нүцгэн эмэгтэй буюу үр төрүүлэгчээр төрөх шүтэн барилдлагыг дүрсэлжээ. ($\lfloor\Box-\chi\Box-\varphi\forall-o\#.$)
12. Өтлөх, үхэх. Сансрын хүрдэнд үүнийг унахгүйн тулд хоёр гараараа тэнцвэр олж ядан буй өтөл бөгтөр өвгөн хийгээд үхдэлээр дүрсэлжээ. ($\pi!-\forall\kappa-\mu\#-\kappa\delta-\{!-o\omega!-\psi\#.\#$)

Бурхны шашны үндсэн сургаал болох үйл, үйлийн үрийн тухай ойлголтыг сүсэгтэн бүхэнд сануулж байх учиртай тул энэхүү шүтэн барилдлага ($\Phi\forall\lambda-\omega\forall\zeta.$) –ыг сансрын хүрдэнд аливаа орчлонгийн амьдрал нь өөр хоорондоо арван хоёр барилдахуйгаар шүтэлцэж оршихыг эдгээр зургуудаар ухааруулан үзүүлжээ.

Энэхүү сансрын хүрдэн хэмээх зургийг сүм хийдийн үүдэнд дэлгэж, сансар орчлонгийн мөн чанарыг таниулдаг байхээ.” [9.35-39, 7.207-208]

Ингэж эх болсон хамаг амьтан зургаан зүйлийг сансрын хүрднээ дүрсэлж, ард түмэнд ухуулан таниулдаг байсан ба маанийн зургаан үсгээ уншиж, номын дээд хэмээн шүтэн ирсэн бөлгөө

“Дээр дурьдсан бүх зүйл хүрдний байрлалтайгаар дугуйран орших ба үхлийн эзний ам, дөрвөн мөчөөр чанга баригдсанаар дүрслэгддэг. Ингэж дүрсэлснээр үйл, нисваанисын эрхээр энэ орчлонд төрөл авах бүгд, үхлийн

эзний эрхэнд байх ба хэдий чинээн орчлонгийн ёзоорыг үл тэвчинэ, төдий чинээ төрөх, үхэхийн зовлон тэргүүтнийг амсаж, сансрын үзүүрээс⁹-ээс нэрвэлтгүй там¹⁰ хүртэл үргэлжид тэнэхийг илэрхийлнэ. Мөн ертөнцийн орон тэр бүгд үхлийн эзний дөрвөн мөчөөр чанга баригдсан байх нь үйлийн эрхээр төрж, эвдэрдэг мөнх бусыг бэлгэддэг билээ. Баруун талын дээд хэсэг дэх сар нь хорихын үнэнийг бэлгэдэнэ. Харин түүнийг Бурхан багш мутраа дэлгэн заасан нь амирласан нирваан дүрийг олохгүй бол орчлонгийн зовлонт далайгаас хэзээ ч гэтлэх арга байхгүй тул амьтан бүхэн зовлонгоос гэтлэхийн арганд ямар ч атугай хичээх хэрэгтэй хэмээснийг дохионы аргаар товчлон үзүүлснийг бэлгэдэж буй юм. Үүнээс гадна дөрвөн үнэний авлага, орхилготой холбогдсон бэлгэдэл байдаг. Үүнд зургаан язгуур амьтны сав шимийг байгуулснаар зовлонгийн үнэнийг, зургийн дундах тахиа, могой, гахай гурваар нисваанисын бүхэн гарахын үнэнийг, түүний гаднах хар цагаан хоёр замаар үйлийн бүхэн гарахын үнэнийг тус тус бэлгэдсэн байна. Арван хоёр шүтэн барилдлагаар орчлонд ямар мэт эргэхийн ёс ба бурхны дүр болон сургаалын үгс тэргүүтнээр мөрийн үнэнийг, сараар хорихын үнэнийг, Бурхан багш мутраа зангаснаар мөрийн үнэнд шүтэн, хорихын үнэнийг олж болохыг харуулан буй юм.

Зургийн төв хэсэгт тахиа, гахай, могой гурзыг зурснаар шунал тачаал, мунхаг сэтгэл, уур хилэн гурвыг төлөөлүүлсэн ба тахиа, могой хоёр гахайн амнаас гарсан мэт дүрсэлснээр шунал уур хоёр мунхгаас үүдсэнийг илэрхийлдэг. Үүгээрээ мунхагийн үндэс, шунал тэргүүтэн бусад муу сэтгэлүүд нь мөчир салаа мэт болохыг номлосон номуудтай машид нийцдэг билээ. Мөн тэдгээрийн гадуурх хар цагаан замын дүрсээр нүгэл буяныг илэрхийлнэ. Түүн дээрх тэнгэрийн байдалт нэгэн доош одож буй дүрслэл нь нүглээр муу заяанд унахыг харуулдаг. Завсарт нь тэнгэр, асури, хүн, адгуус, бирд, тамыг дүрсэлснээр орчлон болон орчлонгийн орныг зургаа хуваан тоолох ёсыг тус тус бэлгэддэг байна." [3.7].

Эцэст нь "Орчлонгийн хотол чуулганд үлэмж шаналсан амьтан хэн бүхэнд ертөнцөөс уйдаx сэтгэлийг төрүүлэхийн тухайд бүтээсэн Бурхны нэгэн уран арга болой." хэмээн ном сударт зарлигласан байдаг.

Арван хоёр. "Маанийн зургаан үсгийн эх арвис тарнийн¹¹ тус эрдэм санаанд багташгүй, түүний нэрийг даган дурьдсан төдийгөөр хилэнц¹² бүгдийг арилгаж чадна. Үлгэрлэх юм бол маш чарийн тоосны тоо хэмжээг барьж (тоолж) чадах уу? Мэдээж үгүй. Маанийн зургаан үсгийн эх тарни үүнийг нижгээдийн төдий урьсны, буяныг тоолж үл чадах болой." хэмээн "Хуурцаганд зохиосны судар"-т өгүүлжээ. "Зургаан үсгийн эх тарнийн алиныг

ч үргэлжид барин өгүүлэхэд хичээсэн амьтад нь буян лугаа төгөлдөр мөн болой. Тэдгээрийг өгүүлэн, үйлдэхийн цагт бурхан ялж төгс нөгчсөнөөр Ганга мөрний элс хэдий чинээнийг хурааж болно. Бодьсадва¹³ нар нарийн тооснуудыг хурааж болдог... Зургаан зүйлийн үсгийн их тарнийн эрдмийг хаа нэгэндээ эсвэл биендээ хадгалваас түүний бие нь очирын¹⁴ бие дор ухагдах болой." хэмээн маанийн ач тусын учрыг судар номонд өгүүлжээ.

Арван гурав. "Маанийг нэг удаа уншваас далан хоёр Ганга мөрний элсний тоо төдий чинээ бурхны нэрийг өгүүлэн тахиснаас үлэмж их бөлгөө. Долоон удаа уншваас бум найман мянган галавт¹⁵ хураасан хилэнц түйтгэр арилах ба зуу буюу мянга уншваас "Ганжуур" уншсан буянтай тэнцэнэ. Нэг түм уншваас гурван муу заяаны үүдийг¹⁶ хаана" [6.65] хэмээн номлосон байдаг. Гурван муу заяа нь бие, хэл, сэтгэлээр үйлдэх арван хар нүгэл буюу нүглийн үүдийг хаана гэсэн үг юм. Маанийг ганц удаа ч болов сонссон шувуу гөрөөс муу заяанаасаа гэтэлдэг гэж өвөг дээдэс маань ярилцаж байхыг нэг биш удаа сонсож байлаа.

Арван дөрөв. Маанийн үсэг зургаа байдгийн учир нь хутагт билгийн чинад хязгаарт хүрсэн зургаан барамидийн¹⁷ утгыг агуулсны тулд хэмээдэг. Харин зургаан үсгийн зэрэгчлэнгийн ач тус нь язгуур зургаан амьтан болох:

- | | |
|-----------|--|
| 1. Тэнгэр | 4. Адгуус |
| 2. Асури | 5. Бирд |
| 3. Хүн | 6. Тамын төрөлхтөний үүдийг хаахад оршдог ба |

Зургаан үсгийн эрх нь зургаан дон¹⁸ болох:

- | | |
|--------------|---|
| 1. Тэнгэрийн | 2. Мамын ¹⁹ |
| 3. Хааны | 4. Газрын эзний |
| 5. Шулмасын | 6. Гаригийн донгоос хамгаалах зэрэг юм. |

Харин зургаан үсгийн зуурдын зургаан өвчинд:

- | | |
|-----------|--|
| - Цагийн | - Халууны |
| - Хийн | - Бадганы |
| - Хүйтний | - Шарын өвчнөөс сэргийлэхийн бэлэгдэл" хэмээжээ. |

Арван тав. "Зуун найман тэмдэг" сударт: "Бурхны хүчин нь Жанрайсигийн лагшинд хурах ба бурхны айлдвар, тарни бүгд зургаан үсэгт хурах учир маань нь гурван цагийн бурхны шим зүрхэн" хэмээдэг болно.

Гурван цагийн бурхан буюу язгуурын гурван бурханд ($\psi|\chi|-\chi|\Xi\pi-\pi\chi\#\lambda-\mu.$):

- Жамъян буюу Манзушир²⁰. Manzyjusri, Төвдөөр Т.: $\omega\pi-\kappa\Pi\delta|$.
- Чагнаадорж буюу Очирваань²¹. Санскритээр Ca: Vajrapani,

Төвдөөр Т.: $\text{TM}\chi-\lambda-\Gamma\#-\Delta\forall$.

- Жанрайсиг буюу Авлоктишевара²² Санскритээр Ca: Avalokitesvara,

Төвдөөр Т.: $\subseteq\lambda-\psi|-\chi\omega!\chi$. гурав

болой.

Бурхан бүхний айлдварыг нэгэн зүгт хураасан Жамъянгийн орон нь Нанхиад²³, бурхан бүхний хүчийг нэгэн зүгт хураасан Очирваанийн орон нь Монгол, бурхан бүхний энэрэн нигүүлсэхүйг нэгэн зүгт хураасан Жанрайсигийн орон нь Төвд хэмээн дээдэс айлддаг. [8. 524]

Арван зургаа. Маанийн зургаан үсгийн шимийн дээд утга нь “Тонилахуй”²⁴ хэмээх юм. Ма Ни нь арга буюу их нигүүлсэхүйн утга бөгөөд Бад Мэ нь билиг буюу хоосон чанарыг илтэд мэдэхүйн утга болно. Ийнхүү арга билгийн салшгүй нэгдэл нь Ма Ни Бад Мэ-гийн утгаар илэрхийлэгддэг аж. Харин арга билгийн хослолыг хос гарын байдлаар ургуулсны бэлгэдэл нь Жанрайсиг болно. Товчлон үзвэл бурхны найман түм, дөрвөн мянган цогцсын утга маанийн зургаан үсэгт хурсан болно.

Найман түмэн, дөрвөн мянган номын цогц гэдэг нь:

Төвдөөр Т.: $\phi\#|-v\exists\delta-oN\kappa-)|-ou!-\otimes\#\delta-$. дөрвөн мянган нүглийн ерөндөгийг²⁵ дөрвөн зүйлд хураангуйлсан бурхан багшийн сургаал юм.

1. Тачаангуйн ерөндөг бүхий хоёр түмэн, мянган номын цогц

/ $\omega\kappa\#\kappa-\phi\chi|-\angle!-\chi\eta\forall\lambda-\mu\#\psi-\eta!-)|-\phi!\chi-\otimes\#\delta-$.

2. Уурын ерөндөг бүхий хоёр түмэн, мянган номын цогц

/ $v\forall-\otimes\delta-\chi!-\chi\eta\forall\lambda-\mu\#\psi-\eta!-)|-\phi!\chi-\otimes\#\delta-$. /

3. Мунхагийн ерөндөг бүхий хоёр түмэн, мянган номын цогц

/ $\chi i!-\pi\exists\chi-\chi!-\chi\eta\forall\lambda-\mu\#\psi-\eta!-)|-\phi!\chi-\otimes\#\delta-$. /

4. Нийт гурван хорын ерөндөг бүхий хоёр түмэн, мянган номын цогц

$\kappa\Box\chi-\chi|\exists\pi-\phi\exists\lambda-\pi\#\delta-o\omega!-\chi\eta\#\lambda-\mu\#\psi-\eta!-)|-\phi!\chi-\otimes\#\delta-$. [8.60-61.97] зэрэг дөрвөн зүйл нь нүглийн дөрвөн ерөндөгт ордог.

Арван долоо. “Маанийн зургаан үсгийн товч бэлгэдлийн тухайд:

“ ~◆ “ **Ом** үсгээр өглөгийн барамид төгсөхийг илэрхийлэх бөгөөд бусдад өглөг өгснөөр ахуй үеийн идээ ундаа, дээл хувцас, орон байрны амгалан төдий бус орчлон нийт болон ялгамжааны их, бага зовлонгоос гэтлэх ашдын аврал аяндаа бүтэхийг бэлгэддэг юм. Мөн а, о, и гурван үсэг нэгдэн хурсны талаас тайлбарлавал төрөх, үхэх, завсрын төрөл гурвыг дардаг гурван лагшинг тус тус танин барихыг ч бэлгэдсэн байна.

“ л “ **Ма** үсгээр тэвчээрийн барамидыг илэрхийлдэг бөгөөд Хутагт Аръяабал бээр Авид²⁶ бурхны дэргэд бодь сэтгэлийг үүсгэн, ерөөлийн тангараг тавьсан мэт номхотгоход бэрх хилэнцэт амьтад нь ханьцашгүй бодь хутгийг олох хүртэл нэг агшинд ч тэсэхэд бэрхтэй гал дотор тоолшгүй олон галавт сууж буй мэт зовлонгийн дотор оршдог боловч бусдын тусыг үл орхин, тэвчээрийг үүсгэхийн үүднээс амьтан бүгдийг эх мэт энэрлээр тэтгэхийг бэлгэдсэн байна.

“ ⇔! “ **Ни** үсгээр зургаан зүйл амьтныг дээш удирдан татахыг бэлгэдэж номлосон байдагчлан цөвүүн цагийн амьтад омог, уур, атаа зэрэг муу сэтгэлээр цагийг өнгөрөөх бөгөөд буяны сэтгэлээр хомс дорой живэх догшрохын хүчит салхиар дэгдсэн модны унгариул мэт хийссэнийг хуран үйлдэх учраас үүнийг гэтэлгэхийн мөрд татахыг харуулж буй бөгөөд суурь янагуух²⁷ төдийд уг үр, шүтэн барилдаж гарсан тэргүүтэн үйлдүүлэгч, үйлдэгчийн бүрэн төгс агуулгын ахуй байдлыг тодруулан бэлгэддэг байна.

“ мк— “ **Бад** үсгээр хүсэшгүй элдэв их, бага зовлонгийн ёзоорыг үндсээр нь таслахыг илэрхийлдэг билээ. Зовлонгийн ёзоорыг таслахад ч хоосон чанарын дияан²⁸ буюу самадын дияанд харгалзах учраас самадын барамидыг бэлгэддэг юм.

“ лV “ **Мэ** үсэг нь галаар түлш бүгдийг шатаан чаддаг мэт тийн цагаан буяны үйл мөрд орох хичээл шамдалын галаар хоёр түйтгэр болон муу авъяасын хирт түлш бүгдийг шатаах бөгөөд ахуй үе ба эцсийн тус амгалан бүхнийг шамдалгүйгээр өгдөг учраас хичээлийн барамидыг илэрхийлэн бэлэгддэг байна.

“ }□* “ **Хум** үсгээр юмс үнэмлэхүй мөн чанараараа үл бүтсэн хэмээгч буюу хоосон чанар, уг үрийн шүтэн барилдлага тэргүүтэн үйлдүүлэгч, үйлдэгч юмс бүхэн яангуух төдийд зохилдон шүтэн барилдаж гарсан хэмээгч хоёрыг харшуулалгүй нөхөрлүүлж авдаг билгийн орон сэлтийг тус тус үзүүлдэг юм. Түүнчлэн “Ма Ни Бад Мэ” хэмээх Аръяабалын алдрыг өгүүлээд “Хум” хэмээснээр “Их энэрэл нигүүлсэлийн мөн чанарган та бээр амьтан биднийг бодь хутаг хүртэл дагаж баригтун. Нирваан болон ханьцашгүй сайн мөрийг түргэн олуулан соёрхогтун” хэмээн соёрхол тавихын ёсыг илэрхийлдэг билээ” [10.7].

Ашигласан ном зохиол

1. Л.Хүрэлбаатар. “Алтан хүрдэн”.-УБ., 1992.

2. В.И.Корнев. "Буддизм и его роль в общественной жизни стран Азии".- Москва.,1983.
3. Д.Дагвадорж. "Буддын гүн ухаан, Монгол уламжлал".-УБ., 2003.
4. Д.Дагвадорж. "Буддын нууц тарнийн ёс, Монгол уламжлал".-УБ., 2004.
5. Ш.Чоймаа, Л.Тэрбиш... "Буддын шашин, соёлын тайлбар толь" Буддын судлал цуврал №1.- УБ., 1999.
6. Л.Эрдэнэчимэг. "Гүр дууны бичиг".-УБ., 1995, 2001.
7. "Илтгэл, өгүүлэл, танилцуулгын эмхтгэл" №1, 2, 3. Буддын соёл судлалын төв.-УБ., 2003.
8. Д.Наранцацрал. "Маань мэгзэмийн ая дангийн дуурьслын онцлог".- УБ.:Сүхбаатар принтинг, 2005.-198х.
9. В.В.Журавлев. "Мир художественной культуры".- Москва.,1987
10. Ж.Бадраа. "Монгол ардын хөгжим".-УБ.,1998.
11. Д.Цэрэнсодном. "Монголын бурхны шашны уран зохиол".-УБ., 1997.
12. "Өдөр тутмын буяны уншлага, ямар мэт үйлдэхүйн ёсон сайтар номлосон чандмань эрдэнийн эрхи хэмээгч оршвой"
η!λ-χε!χ-ζ-κχ∇-ε#ψ-γ!-Υψ-Π-οο!-ρΞζ-ζ∇χ|-μψ-ο{κ-μ-
λ#ψ-οΞω!-|∇δ-ο-υ∇|-Π-ο-ου□χ|-|#. УБ.,1999.
13. Т.Дорждагва. "Соёл, уран сайхны соёл, урлаг".-УБ., 2003.
14. Б.Сумъяа. "Судалгааны ажлын арга зүй".-УБ., 2000.
15. "Wudang lamasery" Бадгар сүм.-ӨМӨЗО.: Бугат хот, 2004.

Нэр томъёоны тайлбар

1. Лагшин-Бурхны биеийн хүндэтгэлийн нэр
 2. Зарлиг-Бурхны хэлийн хүндэтгэлийн нэр
 3. Таалал-Бурхны сэтгэлийн хүндэтгэлийн нэр
 4. Гурван цагийн бурхан-Язгуурын гурван бурхан ордог. Язгуурын гурван бурхан - ψ!χ|-χ|Ξπ-πχ#λ-μ. - авран хамгаалагч
- | | | |
|-------------------------|-------------|------------------|
| -Жамъян (Манзушри) | Санскритээр | Ca.:Manjusri |
| | Төвдөөр | T.: сүүп-кΠδ . |
| -Чагнаадорж (Очирваань) | Санскритээр | Ca.:Vajrapani |
| | Төвдөөр | T.: 1мχ-λ-Γ#-Δ∇. |

-Жанрайсиг (Аволикитишевара) Санскритээр Ca: Avalokitesvara

Төвдөөр Т: $\zeta\lambda-\psi|-\chi\omega!\chi|$.

гурав болой.

5. Бясалгал – Дотроо бодон суух

6. Таван бэлгэ билгүүн - $\xi V-\{V|-P$. Үүнд:

- Толийн бэлгэ билиг ($\pi V-\zeta\delta-Y-/\omega!-\xi V-\{V|$.)

- Тэгш чанарын бэлгэ билиг ($\pi\eta\pi-\mu-\eta!k-\angle!-\xi\gamma-\{V|$.)

- Тусгайд онох буюу тус тус дор (өөр өөр) онохуйн бэлгэ билиг ($|#-|#\psi-\Phi\chi|-\mu\omega!-\xi V-\{V|$.)

- Үйл бүтээлийн буюу үйлсийг бүтээхуйн бэлгэ билиг ($\Pi-o-o\sqcup o-\mu\omega!-\xi V-\{V|$.)

- Номын агаарын буюу чанарын бэлгэ билиг ($\phi\#|-\angle!-k\Pi\delta|-\angle!-\xi V-\{V|$.) 5 ордог.

7. Цогц таван бурхан - Үүнд:

- Толийн бэлгэ билгүүний бурхан Мижиддорж

- Тэгш чанарын бэлгэ билгүүний бурхан Ренчинжумдан

- Тусад дор буюу мөн хэвээр онохын бэлгэ билгүүний бурхан Нанваантаяа

- Үйлийг бүтээх бэлгэ билгүүний бурхан Дон ёд Дондүв

- Номын агаарын бэлгэ билгүүний бурхан Намбар Нанзад зэрэг ордог.

8. Нисваанис – Санскритээр Ca: Klesa $\eta\#\delta:t\#\delta|$. Үүнийг нисваанисын таван хороор тайлабарладаг. – шунал тачаал $\omega k\#\kappa-\phi\chi|$. - урин хилэн

$\otimes!-\pi\Xi\chi$. - эргүү мунхаг $\theta\#\delta|-\mu$. - омог дээрэнгүй $vV-\otimes\delta-$. - атаа найдангуй $|\chi-\kappa\#\lambda$. нар юм.

9. Сансрын үзүүр – Сансар гэдэг нь орчлонгийн нэр, Төвдөөр хорвоо гэдэг. Сансрын хязгаар нь эргэн орчихуйн хязгаар гэсэн утгатай дүйнэ.

10. Нэрвэлтгүй там – Тамд нэрвэгдэх

11. Эх арвис тарни – Эх баригч тарни

12. Хилэнц – Нүгэл

13. Бодьсадва – Санскритээр Ca: $\Pi o-\phi\Xi o-|\gamma\pi|-\kappa\mu\omega$. Bodhi гэгээрэл, төгс мэдлэг гэж орчуулагдана. Олон хүнд тустай үйл хийдэг хүн.

14. Очир – Ваджра буюу Базар хэмээх Санскрит нарийн Монголжсон дуудлага

15. Галав – Нэгэн бурхны орших цаг хугацаа

16. Гурван муу заяаны үүд - $\delta\lambda-|\# \delta|-\chi|\exists \pi$. муу дло одно гэж орчуулагдана.
Үүнд: там, бирд, адгуус гурав ордог.
17. 6 барамид - $v-\psi\#\zeta-k\Box-^{\text{TM}}!\lambda-\mu$. Үүнд: - өглөг, - шагшабадь буюу сахих ёс, - хүрэлцэхүй буюу тэсвэр, - хичээнгүй, - дияан бясалгал, - билэг буюу оюун 6 ордог.
18. Дон - $\omega k\#\lambda$. ад шүглэх
19. Мам – Асури тэнгэрийн эзэн
20. Манзушри – Санскритээр Са: $\omega\pi-k\Pi\delta|$. Manjusri – зөөлөн эгшигт буюу билгүүн, оюун ухааны тэтгэгч, мэргэд бүгдийн оройн чимэг
21. Очирваань – Мутартаа очиртой гэж орчуулагддаг.
Санскритээр Са: $^{\text{TM}}\chi-\lambda-\Gamma\#-\Delta\forall$. Чагнаадорж буюу Жалханз хутагт
22. Аволокитишевара – 4-тэй ижил
23. Нанхиад – Өмнө зүгийн Хятад
24. Тонилахуй – Тонилох, гэтлэх гэсэн үг
25. Ерөндөг – Хорыг тайлдаг гол оньс
26. Авид – Санскритээр Са: Abitha – аймшиггүй гэж орчуулагддаг.
Аминдаваа бурхан гэдэг нь үүнээс гаралтай.
27. Янагуух – Харьцангуй гэсэн үг
28. Хоосон чанарын буюу самадын дияан - $\otimes\#\delta-\eta!k$. Хоосон чанарыг онох ухааныг хэлж байна.